



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/53/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.15 № 35
танай _____-ны № _____-т

ОЮУ ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.БОЛОРМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Оюу цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Оюу цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89 831 625,09	86 580 581,65
33	АВЛАГА	-	1 251 255,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1 146 819,00
335	Бусад авлага	-	104 436,00
3351	Байгууллагаас авах авлага	-	104 436,00
35	БАРАА МАТЕРИАЛ	89 831 625,09	85 329 326,65
351	Түүхий эд материал	88 850 505,09	85 328 526,65
35110	Тусгай зориулалттай материал	86 829 245,09	84 165 686,65
35130	Эм боох материал	2 021 260,00	1 162 840,00
354	Хангамжийн материал	981 120,00	800,00
35420	Аж ахуйн материал	800,00	800,00
35460	Хүнсний материал	980 320,00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 246 822 591,01	2 316 501 249,87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 246 822 591,01	2 316 501 249,87
392	Биет хөрөнгө	2 054 747 590,93	2 124 563 749,75
39201	Барилга, байгууламж, орон сууц	2 077 719 594,24	2 199 199 594,24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(92 043 964,47)	(138 576 488,38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63 231 725,00	74 531 225,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40 588 108,09)	(45 580 399,72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114 385 257,40	114 385 257,40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67 956 913,15)	(79 395 438,79)
393	Биет бус хөрөнгө	192 075 000,08	191 937 500,12
39301	Програм хангамж	1 230 000,00	1 230 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(954 999,92)	(1 092 499,88)
39303	Бусад биет бус хөрөнгө	191 800 000,00	191 800 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2 336 654 216,10	2 403 081 831,52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1 898 000,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1 898 000,00
413	Өглөг	-	1 898 000,00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1 898 000,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2 336 654 216,10	2 401 183 831,52
51	Засгийн газрын хувь оролцоо	2 336 654 216,10	2 401 183 831,52
511	Засгийн газрын хувь оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191 800 000,00	191 800 000,00
512	Хуримтлагдсан үр дүн	406 300 306,34	470 829 921,76
51210	Өмнөх үеийн үр дүн	406 300 306,34	406 300 306,34
51220	Тайлант үеийн үр дүн	-	64 529 615,42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 738 553 909,76	1 738 553 909,76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2 336 654 216,10	2 403 081 831,52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	613 893 300,00	726 779 850,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17 129 800,00	141 735 750,00
120	Нийтлэг татварын бус орлого	17 129 800,00	141 735 750,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17 129 800,00	141 735 750,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17 129 800,00	141 735 750,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	596 763 500,00	585 044 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	555 244 000,00	542 364 600,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	555 244 000,00	542 364 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1 160 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	880 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41 519 500,00	41 519 500,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41 519 500,00	41 519 500,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	676 104 823,97	662 250 234,58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676 104 823,97	662 250 234,58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662 210 967,16	649 270 965,43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	441 258 299,73	441 088 922,00
210101	Үндсэн цалин	311 523 935,14	339 130 455,00
210102	Нэмэгдэл	97 077 538,59	66 774 480,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15 726 141,00	1 615 600,00
210104	Урамшуулал	16 930 685,00	33 568 387,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57 548 479,39	59 468 700,00
210201	Тэтгэврийн даатгал	39 951 979,39	41 533 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 399 100,00	4 483 700,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 519 300,00	3 587 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	879 800,00	896 700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 798 300,00	8 967 400,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31 160 050,67	33 447 608,85
210301	Гэрэл, цахилгаан	2 726 341,90	3 999 732,46
210302	Түлш, халаалт	22 050 643,16	20 107 123,19
210303	Цэвэр, бохир ус	6 383 065,61	9 340 753,20
2104	Хангамж, бараа материалын зардал	25 346 656,00	17 240 358,44
210401	Бичиг хэрэг	193 400,00	1 153 150,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	155 924,00	126 900,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4 391 980,00	228 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12 698 900,00	7 824 300,00
210408	Бараа материал акталсны зардал	7 906 452,00	7 908 008,44
2105	Нормативт зардал	39 518 440,00	31 518 335,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55 200,00	886 620,00

210502	Хоол, хүнс	39 429 740,00	30 525 715,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33 500,00	106 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 863 000,00	2 284 200,00
210604	Урсгал засвар	1 863 000,00	2 284 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 030 000,00	1 122 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 030 000,00	1 122 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64 486 041,37	63 100 841,14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 091 100,00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62 394 941,37	63 100 841,14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13 893 856,81	12 979 269,15
2132	Бусад урсгал шилжүүлэг	150 000,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	72 000,00	5 787 691,15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	72 000,00	5 787 691,15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13 671 856,81	7 191 578,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13 671 856,81	7 191 578,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(62 211 523,97)	64 529 615,42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(62 211 523,97)	64 529 615,42

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191 800 000,00	1 738 553 909,76	406 300 306,34	2 336 654 216,10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	64 529 615,42	64 529 615,42
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191 800 000,00	1 738 553 909,76	470 829 921,76	2 401 183 831,52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	600 345 491,00	594 167 640,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	600 345 491,00	594 167 640,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	555 244 000,00	542 364 600,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	555 244 000,00	542 364 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72 000,00	1 160 000,00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	880 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280 000,00
131106	Төсвийн урамшуулал	72 000,00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41 519 500,00	41 519 500,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41 519 500,00	41 519 500,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3 509 991,00	9 123 540,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3 509 991,00	9 123 540,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	600 345 491,00	594 167 640,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600 345 491,00	594 167 640,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582 941 643,19	572 064 830,85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440 449 159,13	442 340 177,00
210101	Үндсэн цалин	311 523 934,54	340 382 710,00
210102	Нэмэгдэл	97 077 538,59	66 773 480,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15 726 141,00	1 615 600,00
210104	Урамшуулал	16 121 545,00	33 568 387,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57 548 479,39	59 468 700,00
210201	Тэтгэврийн даатгал	39 951 979,39	41 533 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 399 100,00	4 483 700,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 519 300,00	3 587 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	879 800,00	896 700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 798 300,00	8 967 400,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31 160 050,67	33 447 608,85
210301	Гэрэл, цахилгаан	2 726 341,90	3 999 732,46
210302	Түлш, халаалт	22 050 643,16	20 107 123,19
210303	Цэвэр, бохир ус	6 383 065,61	9 340 753,20
2104	Хангамж, бараа материалын зардал	6 827 764,00	1 640 600,00
210401	Бичиг хэрэг	193 400,00	437 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	155 924,00	126 900,00
210404	Ном, хэвлэл	-	98 700,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6 130 240,00	628 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348 200,00	350 000,00
2105	Нормативт зардал	40 661 490,00	28 608 895,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206 200,00	90 600,00
210502	Хоол, хүнс	39 387 790,00	27 647 395,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 067 500,00	870 900,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 864 000,00	2 284 200,00
210604	Урсгал засвар	1 864 000,00	2 284 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	1 030 000,00	1 122 000,00

	үйлчилгээний төлбөр, хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 030 000,00	1 122 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 400 700,00	3 152 650,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 400 700,00	3 152 650,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17 403 847,81	22 102 809,15
2132	Бусад урсгал шилжүүлэг	3 659 991,00	9 123 540,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3 509 991,00	9 123 540,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8 567 449,33	5 787 691,15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8 567 449,33	5 787 691,15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5 176 407,48	7 191 578,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5 176 407,48	7 191 578,00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	583 884 100,00	570 904 830,85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	583 884 100,00	570 904 830,85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583 884 100,00	570 904 830,85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446 372 400,00	442 340 177,00
210101	Үндсэн цалин	256 529 300,00	340 382 710,00
210102	Нэмэгдэл	147 328 600,00	66 773 480,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4 018 200,00	1 615 600,00
210104	Урамшуулал	38 496 300,00	33 568 387,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59 468 700,00	59 468 700,00
210201	Тэтгэврийн даатгал	41 533 900,00	41 533 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 483 700,00	4 483 700,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 587 000,00	3 587 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	896 700,00	896 700,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 967 400,00	8 967 400,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39 235 300,00	33 447 608,85
210301	Гэрэл, цахилгаан	8 144 600,00	3 999 732,46
210302	Түлш, халаалт	25 929 600,00	20 107 123,19
210303	Цэвэр, бохир ус	5 161 100,00	9 340 753,20
2104	Хангамж, бараа материалын зардал	961 000,00	860 600,00
210401	Бичиг хэрэг	157 800,00	157 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	127 800,00	126 900,00
210404	Ном, хэвлэл	98 700,00	98 700,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	292 600,00	128 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	284 100,00	350 000,00

2105	Нормативт зардал	30 803 700,00	28 608 895,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90 700,00	90 600,00
210502	Хоол, хүнс	29 841 900,00	27 647 395,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	871 100,00	870 900,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 284 200,00	2 284 200,00
210604	Урсгал засвар	2 284 200,00	2 284 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 322 800,00	1 122 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 122 800,00	1 122 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 274 700,00	2 772 650,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 774 700,00	2 772 650,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	583 884 100,00	570 904 830,85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	542 364 600,00	536 576 908,85
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	542 364 600,00	536 576 908,85
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41 519 500,00	34 327 922,00
132001	Орон нутгийн төсвөөс	41 519 500,00	34 327 922,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 160 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 160 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 160 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	780 000,00
210401	Бичиг хэрэг	280 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 160 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 160 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	880 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд тухайн нас бүрт нь таарсан боловсрол, өөрийгөө илэрхийлэх арга барил, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагаа явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 583,844.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,838.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,086.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,427.6 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0.0
Бараа материал	89,831.6	85,329.3	(4,502.3)
Үндсэн хөрөнгө	2,246,822.6	2,316,501.2	69,678.6
Нийт хөрөнгө	2,336,654.2	2,403,081.8	66,427.6
Өр төлбөр	0.0	1,898.0	1,898.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,336,654.2	2,401,183.8	64,529.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,336,654.2	2,403,081.8	66,427.6

Бараа материалын данс 85,329.3 мянган төгрөг болж өмнөх оноос 4,502.3 мянган төгрөгөөр буурсан нь урд онд их хэмжээний үлдэгдэлтэй байсан хоол хүнсний материалуудын татан авалтыг багасгаж үлдэгдлийг зарцуулсан ба эрхлэгчийн А/88 дугаар тушаалаар 7,908.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал актласантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,316,501.2 мянган төгрөг болж өмнөх оноос 69,678.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээгээр буурч, 121,480.0 мянган төгрөгөөр БШУГ-аас агааржуулалтын тоног төхөөрөмжийг бүртгэж авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,401,183.8 мянган төгрөг болж 64,529.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Оюу цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 562,814.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 562,814.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 20,450.0 мянган төгрөгөөр бууруулан 542,364.6 мянган төгрөгөөр батласан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 542,364.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 41,519.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нэмэлт санхүүжилтаар 1,160.0 мянган төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 570,904.8 мянган төгрөгийг зарцуулж, 7,191.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 5,787.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 570,904.8 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 4,032.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,787.7 мянган төгрөг, хангамж бараа материалы зардлыг 100.4 мянган төгрөг, норматив зардлыг 2,194.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУГ-аас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, Орхон аймгийн ЭМГ-аас эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар шалгарч шагналд 380.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 280.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 280.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 380.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Оюу цэцэрлэг нь 2021 онд 565,738.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 528,255.8 мянган төгрөгийн 138 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 37,512.6 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 12,315.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 7,906.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 4,358.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 50.4 мянган төгрөг 1 зөвлөмжийн биелэлтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	1	4,358.3	1	4,358.3			
Зөвлөмж	1	50.4	1	50.4			
Нийт дүн	2	4,408.7	2	4,408.7			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацааны эцэст өр авлага үүсгэхгүй байж, төсвийг зөв зохистой удирдах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 3,149.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээр, тайлант хугацааны эцэст өглөг авлагын үлдэгдэлтэй гарсан 3,149.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж, Шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

Тайлант онд гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.3 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 11, 12-р сарын 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх.

2. Авлага өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 1,251.3 мянган төгрөгийн авлага, 1,898.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зүй зохистой удирдан, тайлант оны эцэст авлага өглөг үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Оюу цэцэрлэг	2	3,149.3							2	3,149.3
Нийт		2	3,149.3							2	3,149.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ийн ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


6117143690
ΦΑΑ0073 9042808

Ц.НАРМАНДАХ